Гадаад оюутнуудад зориулсан

гарын авлага

Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах

Боловсролын яам

Их сургууль доторхи бэлгийн дарамт болон хүчирхийллийг таслан зогсоох төв

Солонгосын Эмэгтэйчүүдийн Бодлогын Хүрээлэн

Гадаад оюутнуудад зориулсан

гарын авлага

Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах

Боловсролын яам

Их сургууль доторхи бэлгийн дарамт болон хүчирхийллийг таслан зогсоох төв

Солонгосын Эмэгтэйчүүдийн Бодлогын Хүрээлэн

Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах

Гадаад оюутнуудад зориулсан

гарын авлага

Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах

Энэхүү гарын авлагыг Боловсролын яамнаас их сургуулийн орчинд бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллийг үндсээр нь таслан зогсоох, хүйсийн эрх тэгш байдлыг бүрдүүлэхийн тулд хэрэгжүүлж буй “Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох төв” төслийн хүрээнд БНСУ-д их сургуульд суралцаж буй гадаад оюутнуудад зориулж гаргав.

Уг гарын авлагад үндсэн гарын авлагын агуулгыг нэмж сайжруулан шинэ мэдээллийг багтаасан болно.

Гарын авлагыг гадаад оюутнууд сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглах боломжтой бөгөөд бодит нөхцөл байдал янз бүр байх магадлалтай тул хувь хүний үзэл бодол, шийдвэрээс үүдсэн үйлдэлд тухайн хүн өөрөө хариуцлага хүлээнэ.

Хэвлэсэн огноо : 2023 оны 12 сар

Эрхлэн гаргасан : Боловсролын яам, Их сургууль доторхи бэлгийн дарамт болон хүчирхийллийг таслан зогсоох төв (Солонгосын Эмэгтэйчүүдийн Бодлогын Хүрээлэн)

БНСУ-д
тавтай морилно уу!

БНСУ-д суралцахаар ирсэнд тань баяр хүргэе!

БНСУ-ын соёл, хууль дүрэмтэй адил төстэй эсвэл ялгаатай соёл, хууль дүрэмтэй улсаас ирсэн оюутнууд ч их байдаг. Солилцооны оюутнаар нэг улирал суралцахаар ирсэн, эсвэл шинээр элсэн орж оюутны амьдралаа эхэлж байгаа, мөн магистр, доктор, судлаачийн хөтөлбөрт хамрагдахаар Солонгос улсыг зорьж ирсэн хүн ч цөөнгүй бий гэж бодож байна.

Дотны гэр бүл, найз нөхдөөсөө холдон харь оронд амьдарна гэдэг амаргүй даваа. Тухайн улсын соёл, нийгэмд дасан зохицон амьдрах ч мөн амаргүй даваа. Мэдээж хэрэг тэдгээр асуудлуудаас үл хамааран амьдралын нөхцөл байдалдаа хурдан дасан зохицож зугаатай сайхан амьдрахыг хүсэж байгаа ч биднээс үл шалтгаалах зарим нэг хэцүүхэн нөхцөл байдалтай тулгарах магадлал бий гэдгийг мартаж болохгүй.

Иймд та бүхэнд их сургуулийн орчинд тулгарч болзошгүй бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллийн талаарх дараах мэдээллүүдийг танилцуулж байна. БНСУ-ын засгийн газар болон таны суралцаж буй их сургууль та бүхнийг бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллээс хамгаалахад хэзээд бэлэн байх болно. БНСУ-ын ард иргэд бэлгийн дарамт, хүчирхийллийг маш ноцтой асуудалд тооцон ямар ч албан тушаалтныг албан тушаалаас буулгах, сургуулиас хөөх, эрүүгийн ял оноох хүртэл хүнд шийтгэл ноогдуулдаг.

Та бүхнийг БНСУ-д суралцах хугацаандаа эрүүл аюулгүй амьдрахад энэхүү гарын авлага тус болно гэдэгт итгэлтэй байна.

БНСУ-ын их сургуульд
суралцаж буй гадаад оюутны байр суурь

Гадаад хүн БНСУ-д суралцахын тулд эхлээд суралцах виз эсвэл энгийн сургалтын виз зайлшгүй авах шаардлагатай. Оюутны статусаар амьдарч байгаа оюутан БНСУ-д суралцах хугацаандаа дараах хуульзүйн эрх эдэлнэ.

Жолооны үнэмлэх авах

БНСУ-д хууль ёсоор амьдарч буй гадаад иргэн солонгос, англи, хятад, вьетнам хэлээр шалгалт өгөн хууль ёсны дагуу жолооны үнэмлэх авах боломжтой.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдах

Гадаад оюутан БНСУ-ын эмнэлэгт эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт эдлэхийн тулд “Улсын эрүүл мэндийн даатгал”-д бүртгүүлэх шаардлагатай. “Улсын эрүүл мэндийн даатгал”-д бүртгүүлэх заавар, эдлэх хөнгөлөлтийн талаарх мэдээллийг БНСУ-ын эрүүл мэндийн даатгалын газрын цахим хуудас(https://www.nhis.or.kr)-наас авах боломжтойгоос гадна харьяа сургуулийн Гадаад оюутныг дэмжих төв болон англи хэлээр зөвлөгөө өгдөг лавлах төв(Tel: 033-811-2000)-өөс утсаар лавлах боломжтой.

Банкны үйлчилгээ авах

БНСУ-ын дотоодын санхүүгийн байгууллагын дүрэм журмын дагуу гадаад оюутан төрөл бүрийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авах эрхтэй.[1)]

Ажил эрхлэх

БНСУ-д гадаад оюутан цагийн ажил хийх боломжтой бөгөөд гадаад оюутны ажил эрхлэх боломжит цаг нь суралцаж буй шатлал, солонгос хэлний чадвар зэргээс шалтгаалан харилцан ялгаатай байдаг учир харьяа сургуулийн гадаад оюутан хариуцсан ажилтнаасаа лавлах шаардлагатай.

* Эх сурвалж: БНСУ-ын Олон Улсын Боловсролын Газар(2021). Гадаад оюутны гарын авлага 2021.

Гарчиг

Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах

Гадаад оюутнуудад зориулсан

гарын авлага

Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах

01 Оюутны хотхонд аюулгүй амьдрах нь 08

02 Дотно харилцааны аюулгүй байдал 11

03 Үерхлийн аюулгүй байдал 16

04 Араас мөшгөх гэмт хэрэг 19

05 Цахим орчны бэлгийн гэмт хэрэг 20

06 Тусламж авах 23

01

Оюутны хотхонд аюулгүй амьдрах нь

Их сургуулийн орчинд бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл элбэг тохиолдохгүй хэдий ч бидний эргэн тойронд үүсэж болзошгүй эрсдлүүдийн нэг билээ. Их сургуулийн орчинд олон төрлийн хүмүүс олон төрлийн харилцаанд орж байдаг тул бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл нь дан ганц оюутан хоорондын харилцаа бус оюутан ба туслах багш, оюутан ба профессор, оюутан ба ажилтан, мөн профессор хооронд, ажилтан хооронд ч тохиолдож болзошгүй.

Ийм асуудлыг шийдвэрлэхээр сургууль бүр бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллийн үед авах арга хэмжээг нарийн зохицуулж журамласан байдаг ба тэр нь албан тушаал(профессор, ажилтан, оюутан), иргэншилээс үл хамааран тухайн сургуулийн бүрэлдэхүүнд багтдаг л бол тус журмыг баримтлах үүрэг хүлээдэг. Тухайн сургуулийн дотоод журмын дагуу уг хэргийг шийдвэрлэдэг тул үүнд соёлын ялгаа ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно.

Зарим тохиолдолд бидний төсөөлж ч байгаагүй эргэн тойрны хэн нэгэн бэлгийн дарамт үзүүлэх, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөн өөрийн эрх мэдлийг урвуулан ашиглаж бэлгийн дарамт үзүүлэх зэрэг тохиолдлууд цөөнгүй. Сургуулийн орчинд эрх мэдлээ ашиглан бэлгийн дарамт шахалт үзүүлэх, заналхийлэх, албадан хүч хэрэглэх, хүчиндэхийг завдах, бэлгийн харилцаатай холбоотой үг хэллэгээр доромжлох, хэт ойртох зэрэгтэй холбоотой бодит жишээтэй танилцацгаая.

Сургуулийн орчинд(Хичээл)

Сургуулийн орчинд хичээлийн цагаар, эсвэл хичээлтэй холбоотой үйл ажиллагаа(уулзалт, тэнхимийн үйл ажиллагаа)-ны үеэр оюутан, туслах багш, профессор, ажилтны хэн нэгэн эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглаж оюутанд давуу байдал үүсгэх, сүрдүүлэх, эсвэл хуурч бэлгийн дарамт үзүүлэх зэрэг нөхцөл байдлууд үүсэж болзошгүй байдаг. Ийм тохиолдол тийм элбэг биш боловч санаанд оромгүй байдалд, санаанд оромгүй хэн нэгэн бэлгийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэдгийг бүү мартаарай.

Хохирол учруулагч Профессор(туслах багш, ажилтан) ➤ Хохирогч Оюутан

» Хичээлийн цаг дээр хичээлийн агуулгыг ойлгуулах зорилгоор, мөн хичээлтэй холбоогүй бэлгийн чиг хандлагатай үг яриаг оюутнуудын өмнө ярих юмуу тийм агуулгатай яриа өдөөж оюутнуудаар яриулах, шаардлагагүй тохиолдолд биеийн аль нэг хэсэгт хүрэх тохиолдол.

Жишээ:
“Чи гоо сайхны мэс засал (хөх) хийлгэж, жингээ хасаж байж л найз залуутай болно.”
“Миний гуяыг бариад өг.”, “Араас тэвэр дээ.” гэж хэлэх.
“Чи өнөөдөр их задгай хувцасласан байна шүү. Шөнийн ажилд гараа юу?”
“Нэг хөнжилд орох гэж л эсрэг хүйстэнтэйгээ үерхдэг биз дээ?”
“Чамайг эсрэг хүйстэн чинь өдөж байсан уу? Яаж өдөж байсан бэ?”

» Шаардлагагүй тохиолдолд холбоо барих мөн ажилд зуучлах, тэтгэлэг, зөвлөгөө, хичээл, судалгаа зэрэг хичээл номтой холбоотой асуудлаар ганцаарчлан уулзахыг хүсэх юмуу сүрдүүлэх тохиолдол

Жишээ:
“Гэртээ ирсэн ч санаанаас минь чи гарахгүй байна.”, “Чамтай хайранд умбаж байна гэж төсөөллөө.”
“Надтай болзвол чамайг “А” гаргаж, профессорын тодорхойлолт бичиж өгнө шүү.”
“Хамт далай явъя.”, “Буудал орж үзсэн үү?”, “Гараас чинь барья.”

Хохирол уцруулагч Оюутан ➤ Хохирогч Оюутан

- Тэнхимийн групп чат, багийн даалгаварт зориулж нээсэн групп чатанд бэлгийн чиг хандлагатай үг яриа бичих, биеийн аль нэг хэсгийг дурдаж гадаад төрхийг дүгнэх тохиолдол

“Дараад авмаар санагдчихлаа.”
“Чи А-тай ямар шатандаа явж байгаа вэ?”
“А ёстой сайхан биетэй, царай зүсний хувьд Б хамгийн хөөрхөн.”

- Бэлгийн утга агуулгатай мессеж, зураг, бичлэг зэргийг өөрийн дураар илгээх юмуу үзүүлэх

Бэлгийн дарамт үзүүлсэн этгээдийг шийтгэх боломжтой юу?

Бэлгийн дарамт, хүчирхийлэл үйлдэгдсэн цаг үе болон үйлдэгдэхийн өмнөх, дараах нөхцөл байдлыг харгалзаж үзэх шаардлагатай байдаг учраас сургуулийн орчин дахь бэлгийн дарамтыг хууль зүйн хувьд эрүүгийн ял шийтгэл ноогдуулах боломжгүй тохиолдлууд цөөнгүй байдаг.

Ийм тохиолдолд сургуулийн дотоод журмын дагуу шийдвэрлэх боломжтой бөгөөд хэргийг шийдвэрлэхдээ нэн тэргүүнд “хохирогчийн нөхцөл байдал” буюу хохирогчийн байр сууринаас бодож үзэж шийдвэрлэдэг. Гэхдээ олон нийт энэхүү үйлдлийг хэрхэн хүлээж авч байгааг ч мөн харгалзан үздэг байна. Тухайлбал адилхан нөхцөл байдалд хохирол учруулагчийн цаад санаанаас үл хамааран олонхид таагүй мэдрэмж төрүүлж байвал шийтгэл хүлээх боломжтой байдаг тул хувь хүн өөрийн үг яриа, үйлдэлдээ хариуцлагатай хандах ёстойг бүү мартаарай.

02

Дотно харилцааны аюулгүй байдал

Их сургуулийн орчинд хичээлээс гадуурх үйл ажиллагаа, танилцах уулзалт, багийн ажил зэргээс гадна дотносож нөхөрлөхийн тулд аялал зугаалганд явах, нэгнийхээ гэрт зочлох тохиолдол их байдаг бөгөөд зарим тохиолдолд согтууруулах ундаа хэрэглэх үе ч цөөнгүй. Аливаа уулзалт цуглааны үеэр хэдий дотно ч гэлээ тухайн хүний хүсэгүй үйлдлийг тулгаж болохгүй бөгөөд таныг ямар нэгэн хүсэгүй үйлдлийг хийхийг шаардахад татгалзах нь ёсзүйн хувьд буруу зүйл огтхон ч биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

Ямар нэгэн улсын өөр соёлтой хүмүүст хандсан бэлгийн чиг хандлагатай үг яриа нь туйлширсан бодлоос үүдэлтэй буруу үйлдэл юм. Мөн “Солонгосын соёл”-д тооцогдох бэлгийн хүчирхийлэл гэж байхгүйгээс гадна өөрийн улсын соёлд хүлээн зөвшөөрөгддөг хэдий ч Солонгос улсад бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэлд тооцогдон таныг гэмт хэрэгтэн болгож болзошгүй тохиолдол байдаг тул өөрийн хэл яриа, үйлдэлдээ хянамгай хандаж болгоомжлох хэрэгтэй. Солонгос хүн ч бай гадаад хүн ч бай, эрэгтэй ч бай эмэгтэй ч бай иргэншил, соёл, хүйсээс үл хамааран тухайн хүний зөвшөөрөлгүйгээр үйлдсэн үйлдэл нь гэмт хэрэг болж болохыг сайтар санаж яваарай.

Хичээл хамт хийх, дугуйлан, найз нарын уулзалт

- Олон нийтийн газар бусдын талаар бэлгийн утга агуулгатай онигоо ярих, үйлдэл хийх, бэлгийн чиг хандлагатай үг үйлдлээр бусдыг доромжлоход тухайн хүнд таагүй мэдрэмж төрүүлбэл гэмт хэрэгт тооцогдох боломжтой.

Жишээ:

- А улс(арьстан)-ын хүнийг болзоонд урих (эсвэл шөнийг хамт өнгөрөөх) санал тавьбал хэзээ ч татгалздаггүй гэсэн. Б улс(арьстан)-ын хүмүүс сексийн хувьд нээлттэй гэх мэт агуулгатай зүйл ярих
- Согтуурах ундаа хэрэглэж байхдаа тоглоомоор шийтгэл ноогдуулах (хүчээр үнсэлцүүлэх, болзоонд явахыг шаардах гэх мэт)-ыг шаардах
- Танихгүй хүнд хамт суухыг тулган шаардах, шаардлагагүй үед биед зөвшөөрөлгүй хүрэх

Гэртээ урих, найзындаа ганцаарцилж, эсвэл хамт урих, уригдах

Хүсээгүй байхад гэртээ ирээч гэж ахин дахин урьж шаардах, эсвэл урилгагүй зочин ирэх үед болзошгүй гэмт хэргээс сэрэмжлэх нь зүйтэй. Өөрийн болон бусдын хувийн орон зайг хүндлэх хэрэгтэй.

- Гэртээ уулзалт, даалгавар хийж байгаа нэрээр хуурч авчран биед нь зөвшөөрөлгүй хүрэх, хүрэхийг оролдох
- Хамтдаа хоол идэж архи уусны дараа “Гэрт чинь очиж дахиад жаахан сууя.”, эсвэл “Танайд хоноод явъя.” гэх мэтээр хүчлэн бэлгийн харилцаанд орохыг оролдох

Тэнхимийн төрөл бүрийн үйл ажиллагаа, оюутны наадам

- “Бүсгүй хүний хундагалсан архи амттай” гэж шахалтаар архи хундагалуулах
- “А, Б хоёр үнэхээр сайхан зохицож байна.”, “Өерхээд үз. Ингэхэд нууцаар үерхэж байгаа юм биш биз?”, “Хайрын хундага тулгаарай.”, “Ойрхон суу л даа.” гэх зэргээр олон нийтийн дунд хүсээгүй хүнтэй холбон, гар бие хүрэлцэхийг шаардах
- Караокед дуу дуулахдаа зөвшөөрөлгүй тэврэх, хажууд суухдаа биед зөвшөөрөлгүй хүрэх

Энэ тохиолдолд яах вэ?

Дотно харилцаатай хэдий ч зөвшөөрөлгүйгээр үйлдсэн бэлгийн чиг хандлага бүхий бүх үйлдэл нь хүлээн зөвшөөрч болохгүй зүйл гэдгийг ойлгох хэрэгтэй. Хэдийгээр нотолгоо байхгүй байсан ч хохирол учруулагчаас зай барих юмуу шийтгэл оноох шаардлагатай гэж үзвэл их сургуулийн захиргаанд мэдэгдэж болно. Баттай нотолгоо олдохгүй бол нөхцөл байдлын нотолгоо (Жишээ нь: хяналтын камерын бичлэг, дуу бичлэг, гэрч, тухайн нөхцөлийг тайлбарлаж чадах гуравдагч этгээд гэх мэт) ашиглах боломжтой. Хэрэв ямар нэг байдлаар бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон бол Цагдаагийн(112) байгууллагад шуурхай хандаж баримт нотолгоо цуглуулж, шаардлагатай эмчилгээ, тусламж авах хэрэгтэй. Хохирсон мөртлөө цагдаад мэдэгдэх эсэхдээ эргэлзэж байвал ганцаараа шаналалгүй их сургуулийн бэлгийн дарамт, хүчирхийллийн эсрэг төв зэрэг мэргэжлийн байгууллагад заавал хандах хэрэгтэй. Цагдаад мэдэгдсэний дараа сургуулиар хамгаалуулахыг хүсэх юмуу сургуулиас хохирол учруулагчид тусгай арга хэмжээ авхуулахыг хүсвэл сургуулийн харьяа хариуцсан албанд давхар мэдэгдэн тусламж авах боломжтой.

Согтууруулах ундаа хэрэглэсэн үед үнсэлцэх юмуу бэлгийн харилцаанд орсон тохиолдол

- Согтууруулах ундаа хэрэглэж өөрийгөө удирдах чадваргүй болсон үед бэлгийн ямар нэг хавьтлыг хүлээн зөвшөөрөх эсвэл татгалзах чадамжгүй гэж үздэг. Эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлыг ашиглаж бэлгийн хавьтал үйлдсэн тохиолдолд эрхзүйн хувьд хүчингийн гэмт хэрэг, бэлгийн дарамт үзүүлсэнд тооцдог байна.
- Согтуугаар бэлгийн гэмт хэрэг үйлдээд “Согтуудаа би алдаа гаргажээ.” гэх нь гэмт хэргийг цагаатгах шалтгаан болохгүй бөгөөд согтуу байсан ч өөрийн хийсэн үйлдэлд хариуцлага хүлээх шаардлагатай байдаг. Энэ тохиолдолд хохирогч “Тэр өдөр би хэтэрхий согтсон байж.”, “Би өөрийгөө хянах ёстой байсан юм.” гэх мэтчилэн өөрийгөө буруутгах тохиолдол байдаг ч сотгууруулах ундаа хэрэглэсэн байлаа гээд гэмт хэргийн хохирогч болж болно гэсэн үг биш гэдгийг санах хэрэгтэй.

Цагийн ажил хийх үед бэлгийн дарамтад орвол яах хэрэгтэй вэ?

Арбайт гэдэг нь цагаар ажиллан цалинжих боломжтой ажлын хэлбэрийг хэлдэг. Гадаад оюутан цагийн ажил хийхийн тулд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий визтэй байх шаардлагатай бөгөөд зохих хэмжээнд солонгос хэлний чадвар эзэмшсэн байх ёстой байдаг. Мөн цагийн ажил хийхэд сургуулийн зүгээс зөвшөөрөл авах хэрэгтэй байж болзошгүй тул дэлгэрэнгүй мэдээллийг тухайн сургуулийн холбогдох албанаас тодруулна уу.

Цагийн ажил хийх үед хөдөлмөрийн харилцаанд орж байдаг учир зэрэг зиндаа, эрэмбэ дараллын хуьд ялгаа гарах магадлалтай. Тиймээс ажлын байран дээр бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон тохиолдолд цагдаагийн газар болон сургуулийн холбогдох албанд мэдэгдэж шуурхай тусламж авах боломжтой. Шаардлагатай тохиолдолд хохирогч тусламж хүссэн тухайн газраасаа асуудлыг шийдвэрлэх дэмжлэг авч болно. БНСУ-д бэлгийн хүчирхийлэл нь хүнд гэмт хэрэгт тооцогддог учир гадаад оюутан ч дотоодын иргэдийн нэгэн адил эрхзүйн хамгаалалт эдлэх эсвэл шийтгүүлэх боломжтой.

Цаг алдвал ой санамж сарних юмуу өөрчлөгдөх, нотолгоо устаж үгүй болох эсвэл нотлоход хэцүү болох, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөх зэрэг асуудал үүсэж болзошгүй. Ялангуяа чухал нотолгоо болох хяналтын камерын бичлэгийн хадгалах хугацаа богино байдаг тул цаг алдалгүй мэдэгдэх нь зүйтэй.

Ямар нэгэн шалтгаанаар цагдаад мэдэгдэх эсэхдээ эргэлзэх, мэдэгдчихвэл илүү их хохирол амсах вий гэж санаа зовж байгаа бол тухайн асуудлыг хариуцан ажилладаг сургуулийн ажилтанд хандаж зөвлөгөө авах болон тус гарын авлагад дурдсан Тусламжийн төвийн зөвлөх мэргэжилтэнтэй холбогдож мэдэгдэнэ үү.

Бэлгийн дарамтын талаар хохирогч өөрөө төдийгүй ойр дотны хүмүүс цагдаад мэдэгдэх боломжтой байдаг. Тиймээс ойр тойрны хүмүүсээсээ эсвэл гадаад оюутныг дэмжих төв болон зөвлөгөө өгөх төвөөс зөвлөгөө авч тусламж хүсээрэй. Мөн хийж буй цагийн ажил нь сургуультай холбоотой тохиолдолд сургуульд мэдэгдэх боломжтой.

Солонгост архи уух соёл үнэхээр ийм байдаг гэж үү?

Q **Солонгост хүний хундагалж өгсөн архийг авахгүй бол ёс алдсан болох уу?**

A Хэрвээ та хувийн, эрүүл мэндийн, шашин шүтлэгийн шалтгаанаар архи уухгүй гэвэл ихэнх солонгос хүн таныг ойлгоно. Солонгост архи уудаггүй, согтохыг хүсдэггүй хүнийг ойлгож хүндэтгэдэг хүмүүс олширч байгаа. Архи уумааргүй байгаа үедээ “Уухгүй” гэж хэлбэл бусад хүмүүс таныг ойлгох болно.

Q **Сургуулийн үйл ажиллагаа дууссаны дараа заавал хамт хооллож, архи уух ёстой юу?**

A Ямар нэг саналд татгалзсан хариу өгөх нь тухайн хүний өөрийн сонголт шийдвэр байдаг. Албан ёсны үйл ажиллагааны дараа зарим хүмүүс уулзаж хөгжилдөх санал гаргадаг ч заавал дуусах хүртэл нь хамт байх шаардлагагүй. Татгалзахыг хүсвэл “Үгүй” гэж хэлэхэд л болно. Үйл ажиллагааны дараах уулзалтад оролцохдоо согтуурруулах ундаа хэрэглэхийг хүсэхгүй байгаа бол “Уумааргүй байна.” гэдгээ хэлээрэй.

Q **Уугаад сууж байхад архи хундагал гэж тулгавал яах вэ?**

A Дээр үед Солонгос улсад эрэгтэйчүүдийн зүгээс эмэгтэйчүүдийг архи хундагал гэж тулган шаардах нь элбэг байсан боловч одоо үед доод курсийн дүү гэсэн шалтгаанаар эмэгтэй хүнийг архи хундагалахыг тулгах нь бэлгийн дарамтад тооцогдоно. Архи хундагалахыг шахаж шаардаж байгаа нь таалагдахгүй бол таагүй байгаагаа илэрхийлэн татгалзаж болно.

Q **Хамт ууж байхад тоглоомд заавал оролцох ёстой юу?**

A Ууж байхад тоглоом тоглох нь уур амьсгалыг зөөлөдөг хэдий ч хувийн шалтгаанаар архи ууж чадахгүй, уухыг хүсэхгүй байгаа хүний хувьд таагүй санагдаж болзошгүй. Тоглоом тоглохын өмнө хамт тоглох гэж байгаа хүмүүсийнхээ саналыг заавал асуух хэрэгтэй. Хүчилж огт болохгүй бөгөөд тоглохыг хүсэхгүй байгаа бол “Тогломооргүй байна.” гэдгээ хэлэх хэрэгтэй.

03

Үерхлийн аюулгүй байдал

Үерхэж буй дотно харилцаатай хүмүүсийн дунд үүсдэг хүчирхийллийг болзооны хүчирхийлэл гэнэ. Үерхэх хугацаандаа төдийгүй салсны дараа үргэлжлэх хүчирхийлэл ч үүнд хамаатай. Болзооны хүчирхийлэл нь үг ярианы, биеийн, сэтгэлзүй-оюун санааны, бэлгийн гэх мэт хэлбэр нь янз бүр байж болохоос гадна харьцаа дотно байх тусам шийдэхэд хүндрэлтэй, харилцааг сэргээхэд удаан хугацаа зарцуулдаг. Болзооны хүчирхийлэл нь нас, хүйсээс үл хамаарах бөгөөд БНСУ-ын цагдаагийн алба нь болзооны хүчирхийллийг гэр бүлийн, хүүхдийн гэх мэт хүчирхийллийн нэгэн адил хүнд гэмт хэрэгт тооцон хатуу хориглож, хамгаалах арга хэмжээг чангатгаж байгаа билээ. Үерхдэг гэх шалтгаанаар бэлгийн дарамтад орж, өдөр тутмын амьдрал дээр хохирол амсаж байгаа бол эргэн тойрноосоо заавал тусламж хүсээрэй.

Хянаж цагдах

- Намайг хэнтэй хамт байгааг үргэлж шалгаж, миний ажлын хуваарийг байнга хянадаг. Мөн бүх зүйл хүссэнээр нь болохгүй бол уурладаг.
- Миний хувцаслалт таалагдахгүй байна гэж огцом уурлаж, цагийн ажлаа хүртэл боль гэж тулгадаг.
- Өөр хүнтэй уулзуулдаггүй. Шинэ уулзалтад очуулдаггүй.

※ Хянаж цагдах нь аажмаар заналхийлэх, цагдан хорих, хүчирхийлэх зэрэг гэмт хэрэг болж хүндэрсэн тохиолдолд эргэлзэлгүй шууд цагдаад мэдэгдэж тусламж аваарай.

Хүчирхийлэл

Үг яриа, сэтгэл санааны хүчирхийлэл

- Хүссэнээр нь хийхгүй бол уурладаг.
- Маргааны шалтгааныг үргэлж надад тохож буруутгадаг.
- Миний бодол, шийдвэрийг буруутгаж өөрийнх нь хүссэнээр хийхийг ятгаж, шаарддаг.
- Үүрлахаараа гэнэт хараал хэлж, доромжилж, орилж хашхиран заналхийлдэг.
- Салъя гэж мессеж бичихэд гэрийн гадаа ирээд зүгээр орхихгүй гэж сүрдүүлдэг.

Биеийн хүчирхийлэл

- Өөрөөс нь өөр бодолтой байх юмуу муудалцах үед намайг зоддог.
- Хоол идэж байхдаа хэрэлдэж эхэлбэл аяга таваг шидэх юмуу хоолоо асгадаг.
- Хана цохиж юм хум шидэлж заналхийлдэг.
- Хүсэл санаагаа гүйцэлдүүлэх гэж чимхэх юмуу хүчтэй татаж чангаах үйлдлийг давтдаг.

Бэлгийн хүчирхийлэл

- Өөрөөс нь өөр бодолтой байх юмуу муудалцах үед намайг зоддог.
- Надтай бэлгийн харилцаанд орсон тухайгаа ойр тойрныхоо хүнд ярьж дэлгэдэг.
- Надаас нууцаар миний дүрс бичлэгийг хийж байгааг мэдээд устгачих гэхэд устгаагүй.
- Нүцгэн зургаа явуулчих гэж шаарддаг.
- Бэлгийн харилцаанд орж байгаа бичлэг битгий хий гэж хэлээд байхад байнга бичлэг хийе гэдэг.
- Үерхдэг залуу минь хөлсний байранд, байрлаж байгаа газартаа камер байрлуулж бэлгийн харилцааны бичлэгийг нууцаар хийдэг.

Дээр дурдсан болзооны хүчирхийллийн жишээнүүд нь олон гэмт хэргийн нэгээхэн хэсэг бөгөөд үүнээс гадна олон төрлийн тохиолдлууд байдаг. Болзооны хүчирхийллийн хохирогч нь сургуулийн хариуцсан алба, цагдаагийн газрын туслалцаа авах боломжтой. Ялангуяа бие махбодын хүчирхийлэлд өртөх, бэлгийн хүчирхийлэлд өртөх, заналхийлүүлэх, цагдан хоригдох, хүчирхийлэгдсэн тохиолдол нь цаашид ч давтагдах магадлалтай байдаг учир эргэлзэх зүйлгүй цагдаад мэдэгдэж туслалцаа аваарай. Үерхлийн харьцаанд ч цахим орчны бэлгийн гэмт хэрэг гарч болзошгүй бөгөөд энэ талаар 5-р бүлгээс дэлгэрэнгүй уншиж танилцана уу.

Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах

04

Араас мөшгөх гэмт хэрэг

БНСУ-д хүсэгүй байхад нь ямар нэгэн шалтгаангүйгээр харьцахыг оролдох юмуу араас нь даган мөшгөж тухайн хүнд айдас түгшүүр төрүүлэхийг араас мөшгөх гэмт хэрэг гэж тодорхойлдог. Тасралтгүй эсвэл дахин дахин араас мөшгөх тохиолдолд гэмт хэрэгт тооцон шийтгэл ногдуулдаг бөгөөд хэн нэгэн хүн таны араас мөшгөвөл цагдаад мэдэгдэн эрхээ хамгаалуулах боломжтой байдаг.

Өртөгч Мөрдөн мөшгүүлж буй хохирогч, хамтран амьдрагч, гэр бүл

Үйлдэл Эсрэг этгээдийн хүслээс үл хамааран зөвшөөрөлгүй дараах үйлдлүүдийг гаргах

- Ойртох, явах замд саад болох
- Гэр, цагийн ажил хийдэг газрын ойр орчимд хүлээх, удаан харах
- Тасралтгүй утсаар залгах, мессеж явуулах
- Цахим орчинд сэтгэгдэл бичих зэрэг цахим хэлбэрээр ойртохыг оролдох
- Илгээмж илгээх, бэлэг сэлт үлдээх
- Орон байр, гэрийн эргэн тойрны эд зүйлийг сүйтгэх

Араас мөшгөх хэргийн үед авах арга хэмжээ, шийтгэл

Араас мөшгөөд зогсохгүй сүрдүүлэх, орон байранд зөвшөөрөлгүй нэвтрэх тохиолдолд хуулийн арга хэмжээ авдаг. Хэрэг үйлдэгчийн цаад санаанаас үл хамааран хохирогчийн санаа бодлыг үл хүндэтгэсэн үйлдэл бол гэмт хэрэг юм. Тиймээс хэн нэгэн таныг нууцаар мөрдөн мөшгөж байгаа бол эргэлзэлгүй цагдаад яаралтай хандах хэрэгтэй.

Араас мөшгөх гэмт хэрэг үйлдэгчийг БНСУ-ын хуулиар 3 хүртэлх жилээр хорих юмуу 30 сая хүртэлх воноор торгодог. Хэрэв мэс, аюултай эд зүйл биедээ авч явах юмуу тухайн эд зүйлийг ашиглан араас мөшгөсөн тохиолдолд 5 хүртэлх жилээр хорих, эсвэл 50 сая хүртэлх воны торгууль ногдуулна (Араас мөшгөх гэмт хэрэгт шийтгэл ногдуулах хуулийн 18-р зүйл). Хэрэв гадаад оюутан БНСУ-д гэмт хэрэг үйлдвэл тус хуулийн дагуу солонгос иргэдтэй адил шийтгэнэ.

Цагдаад шууд мэдэгдэхэд бэрхшээлтэй үед сургуулийнхаа хариуцсан ажилтантай холбогдож зөвлөгөө авах боломжтой. Сургуулийн орчинд араас мөшгөх гэмт хэргийн улмаас сурч боловсрох эрх зөрчигдвөл сургууль доторх Бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллийн эсрэг төв(хүний эрхийн төв)-д даруй хандан тусламж хүснэ үү. Сургуулийн бодлогоос шалтгаалан авах арга хэмжээ харилцан адилгүй тул сурч буй сургуулийнхаа Зөвлөгөө өгөх төв, Хүний эрхийн төв (Бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллийн эсрэг төв), Гадаад оюутны төв зэрэгт хандана уу.

05

Цахим орчны бэлгийн гэмт хэрэг

Хүн бүр ухаалаг утсыг чөлөөтэй ашиглах боломжтой болсон өнөө үед цахим үйлчилгээ авах, цахимаар харилцах нь олширч байна. Их сургуулийн орчинд ч мөн онлайн хичээл, багийн ажил гүйцэтгэх, даалгавар, хурал зэргийг цахимаар явуулах болсон. Хичээл төдийгүй найз нөхдийн өдөр тутмын харилцаа ч олон нийтийн цахим сүлжээ(SNS)-ээр өрнөдөг болжээ.

Цахим орчны бэлгийн гэмт хэрэг гэдэг нь цахим хэрэгсэл, мэдээлэл холбоо технологийг ашиглан цахим орчин ба бодит орчинд гарах хүчирхийллийг хэлнэ. Цахим орчны бэлгийн гэмт хэрэг нь хохирогчид цахимаар төдийгүй бодит амьдралд хүртэл нөхөж баршгүй хохирол учруулах боломжтой учир БНСУ-ын засгийн газрын цахим орчны бэлгийн гэмт хэргийн талаарх хууль тогтоомжийг улам чангатгаж ард иргэд ч гэсэн хэрэгтэнд хатуу шийтгэл оноохыг шаардаж байна.

Гар утас, компьютер, интернэт зэрэг цахим технологи ашиглан бусдын эрхийг зөрчих үйлдэл нь бүгд цахим орчны бэлгийн гэмт хэрэгт тооцогддог. Ялангуяа үерхлийн харилцаанд цахим орчны бэлгийн гэмт хэрэг гарах магадлал хамгийн их байдаг бөгөөд ийм тохиолдолд шийтгэлээс зайлах аргагүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу эсвэл дүрс бичлэг хийх

- Бие засах өрөөнд камер суурилуулж бичлэг хийх, ухаалаг утасны камераар бичлэг хийх
- Бэлгийн харилцаанд орох үед зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийх
- Хажуугаар өнгөрөх хүмүүсийн биеийн аль нэг хэсгийг зөвшөөрөлгүй дүрсжүүлэх, бичлэг хийх

※ Хууль бус гэрэл зураг, бичлэгт өртсөн тохиолдолд цагдаад мэдэгдэн камерыг нотолгоо болгон өгөх, хууль бус гэрэл зураг авсан, бичлэг хийсэн хүний гадна төрх ба утасны төрөл зэргийг сайтар тогтоон мэдэгдэх.

Гэрэл зураг, дуу, дүрс бичлэгийг түгээх, дамжуулан тараах

- Бэлгийн харилцаа, нүцгэн биеийн гэрэл зураг, бичлэгийг зөвшөөрөлгүй түгээх
- Өөрөө авсан зураг, бичлэгийг зөвшөөрөлгүйгээр бусдад тараах
- Бэлгийн утга агуулгатай зураг, бичлэгт бусдын царайг эвлүүлж тараах

※ Зөвшөөрөлгүй хийсэн бэлгийн утга агуулга бүхий зураг, бичлэгийг тараах, дамжуулан тараах, эсвэл зураг авч бичлэг хийхийг зөвшөөрсөн ч бусдад тараахыг зөвшөөрөөгүй нөхцөлд зураг, бичлэгийг бусдад түгээх нь мөн гэмт хэрэгт тооцогдоно.

Зураг, бичлэгийг бусдад тараах сүрдүүлэг

- Үерхэхээ больё гэхэд бэлгийн харилцааны зураг, бичлэгийг бусдад тараана гэж сүрдүүлэх
- Шаардлагыг нь биелүүлээгүй гэх шалтгаанаар бие эрхтний зургийг нь олон нийтийн цахим сүлжээ(SNS)-д байршуулна гэж сүрдүүлэх

Ийм тохиолдол ч мөн гэмт хэрэг юм

Хууль бус аргаар болон зөвшөөрөлгүйгээр бэлгийн утга агуулгатай зураг бичлэг хийх, хадгалах, үзэх, бусдад дамжуулах, тараах зэрэг нь гэмт хэрэгт тооцогдон шийтгэгддэг. Мөн тухайн хүний зөвшөөрөлгүйгээр нүүр царай, бие хаа, дуу хоолойг бэлгийн чиг хандлагатайгаар засварласан, эвлүүлсэн, боловсруулсан, хуурамч бичлэгийг бусдад тараасан, дамжуулсан бол хуулиар шийтгүүлэх үндэслэл болно.

Цахим орчны бэлгийн гэмт хэрэгтэй тэмцэх

Цахим орчны бэлгийн гэмт хэрэг ч мөн хүнд гэмт хэрэгт тооцогддог. Хэрвээ та тухайн гэмт хэргийн хохирогч болсон бол ялангуяа тухайн зураг, бичлэг олон нийтийн сүлжээнд нийтлэгдэж нийтэд тарсан бол цагдаагийн газар болон холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэн зураг, дуу бичлэг, дүрс бичлэгийг устгуулах туслалцаа хүсэх боломжтой байдаг.

Мэдэгдэх

- Цахим цагдаагийн ерөнхий газар 112
- Цахимаар гэмт хэрэг мэдэгдэх систем(ECRM) (https://ecrm.police.go.kr/minwon/main)
- Радио телевиз, мэдээлэл холбооны нийгэмлэг 1377

Зөвлөгөө авах, хууль бус зураг, бичлэг устгуулах

- Эмэгтэйчүүдийн яаралтай тусламжийн утас
  1366 (24цаг)

- Цахим орчны бэлгийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах төв
  02-735-8994 (Ажлын өдөр 09:00-18:00 цаг)

06 Тусламж авах

Бэлгийн хүчирхийллийг харсан, өөрөө энэ төрлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд их сургуулийн захиргаа, цагдаагийн газарт яаралтай мэдэгдэх хэрэгтэй. Хохирол учруулагч өөр сургуулийн оюутан бол тухайн оюутны харьяа сургуульд мэдэгдэнэ. Гэмт хэргийг мэдэгдсэнээр хохирогч тусламж авах боломж бүрдэх төдийгүй давтан хохирол амсахаас урьдчилан сэргийлж чадна.

Их сургуулиас тусламж авах

Хохирогч сурч буй сургуулиасаа тусламж авах боломжтой. Сургууль бүрийн үзүүлэх тусламж харилцан адилгүй байж болох ч ерөнхийдөө дараах хоёр төрлийн тусламжийг үзүүлдэг.

- Хохирол учруулагчаас тусгаарлах
  Хэрвээ хохирол учруулагчтай нэг сургууль (оюутан, багш, туслах багш, ажилтан гэх мэт) бол хэргийг мэдэгдсэнээр тусгаарлагдах боломжтой.
- Хохирогчид сэтгэлзүйн болон бусад тусламж үзүүлэх
  Тусламж хэрэгтэй бол сургуулийн Бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийллийн эсрэг төв (хүний эрхийн төв), Зөвлөгөө өгөх төв, Гадаад оюутны төв зэрэгт хандана уу.

※ Гадаад оюутан их сургуулийн бүрэлдэхүүний нэг учраас их сургуулиас зохих тусламж авах эрхтэй. Санаа зоволтгүй тусламж хүсээрэй.

Сургуулиас гадуур: Хуулийн байгууллага, төрийн үйлчилгээ

БНСУ-д гарсан гэмт хэргийг хохирол учруулагч болон хохирогчийн иргэншлээс үл хамааран цагдаад мэдэгдэх ёстой.

112 (Цагдаа, яаралтай нөхцөлд)

- 112 руу утасдаж гэмт хэргийн хохирогч болсон эсвэл нүдээр харснаа мэдэгдвэл цагдаа очих болно.
- Утсаар ярихад орчуулгын үйлчилгээ хэрэгтэй бол “Тун-ёг” гэж хэлнэ үү. Тэгвэл танд орчуулгын үйлчилгээ үзүүлэх болно.
- 112 руу утасдахаас гадна мессеж бичиж болно.
- Утсаар ярих боломжгүй үед 112 яаралтай тусламжийн аппликэйшнийг утсандаа суулгавал утсаар ярилгүй 13 улсын хэлээр шууд орчуулгын үйлчилгээ авч хэргийг мэдэгдэх боломжтой.
- **Эмэгтэйчүүдийн яаралтай тусламж 1366 (24цаг)**
  http://www.mogef.go.kr/cc/wcc/cc_wcc_f001.do
  1366 нь Солонгост хаана ч ашиглах боломжтой цорын ганц тусгай утас бөгөөд бэлгийн хүчирхийлэлтэй холбогдох шалтгаанаар яаралтай тусламж, хамгаалал, зөвлөгөө хэрэгтэй бол цаг алдалгүй зөвлөгөө авч эрхээ хамгаалуулах боломжтой 24 цагийн турш үйл ажиллагаа явуулдаг утас юм.

Онлайн: Цахим орчны бэлгийн гэмт хэргийн хохирогч бол

Цахим орчны гэмт хэрэг байж болзошгүй тохиолдолд хохирлыг мэдэгдэж зураг, бичлэг устгах хүсэлт явуулна.

- **Цахим орчны бэлгийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах төв**
  (Digital Sex Crime Victim Support Center) https://d4u.stop.or.kr/

- **Солонгосын цахим орчны бэлгийн гэмт хэрэгтэй тэмцэх төв**
  (Korea Cyber Sexual Violence Response Center) http://cyber-lion.com/

Гадаад оюутнуудад зориулсан

гарын авлага

Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах

Гадаад оюутнуудад
зориулсан

гарын авлага

Их сургуулийн орчин дахь бэлгийн дарамт,
бэлгийн хүчирхийлэл болон
түүнээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах

Зөвлөх комисс

Ян Жүэ
Жоннам их сургуулийн Хүний эрхийн төвийн багийн ахлагч

Жин Сон-э
Ханнам их сургуулийн Оюутанд зөвлөгөө өгөх төвийн зөвлөх мэргэжилтэн

Чвэ Жина
Ёнсэй их сургуулийн Хүйсийн тэгш эрхийн төвийн зөвлөх мэргэжилтэн

Орчуулагч

Аюушжав Нарангэрэл
Намсөүл их сургуулийн ерөнхий эрдэмийн тэнхимийн багш